



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2022/76/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр	
	Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn	
	Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг	
	Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn	
	Ахлах аудитор:	Ж.Бүжинханд
	Утас: 99177546	Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn
	Аудитор	С.Санчирмаа
	Утас: 99282488	Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

ГОВИЙН ИХ ДАРХАН ЦААЗАТ
ГАЗРЫН А ХЭСГИЙН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Ч.БАЯРБАТ ТАНАА

2022.02.24 № 51
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

07020075

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	46.6	35.5
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	525.7	345.1
	Нийт хөрөнгийн дүн	572.3	380.6
	Нийт өр төлбөрийн дүн	0.1	0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	572.2	380.6
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	572.3	380.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	524.6	440.2
	Үйл ажиллагааны зардлын дүн	695.3	631.8
	Үйл ажиллагааны үр дүн	(170.7)	(191.6)
	Үйл ажиллагааны бус үр дүн	0	0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(170.7)	(191.6)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	742.9	572.2
	Тайлант оны үр дүн	(170.7)	(191.6)
	Эцсийн үлдэгдэл	572.2	380.6
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	485.1	420.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	485.1	420.1
	Үйл ажиллагааны ЦМГ	0	0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	0	0
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0	0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	389.5	325.6
	Урсгал зардал	389.5	325.6
	Хөрөнгийн зардал	0	0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	389.5	404.4
	Улсын төсвөөс санхүүжих	382.2	403.7
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	7.3	0.7

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Говийн их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргаа нь “Цөлийн бүсийн эмзэг экосистемийн унаган төрхөөр, нэн ховордсон амьтан ургамлыг амьдрах орчинтой нь хамгаалахын сацуу, түүх, соёлын өвийг хамгаалах, танин мэдэх, зохистой

ашиглах, улмаар бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах” эрхэм зорилгын дор үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

Дөрөв. Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 2021 оны 429.2 сая төгрөгийн 32 мэдээллийг ил тод байршуулахаас 49.7 сая төгрөгийн 16 мэдээллийг ил тод байршуулж, 379.5 сая төгрөгийн 16 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Санхүүгийн тайлангийн аудитаар тендерт шалгараагүй иргэн аж ахуйн нэгж байгууллагаас 1.9 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Захиалагч бараа, ажил, үйлчилгээ

худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна” гэсэн заалттай нийцээгүй байна

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар:

- бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулах
- төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх
- хөрөнгийн тооллогын бүртгэл
- тээвэр шатахууны зарцуулалтыг үзэх нь зүйтэй.

Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 70.8 сая төгрөгийн газрыг орхигдуулан тоолсон нь тооллого комиссын гишүүд, тооцоо бодон хянасан нягтлан бодогчийн хариуцлагагүй байдалтай холбоотой тул дараагийн удаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарах.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 14.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9.9 сая төгрөгийн алдааг залруулж, 0.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Залруулсан алдаа

Нэр бүхий 8 компаниас 9.9 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг гаргуулаагүй байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн.

Төлбөрийн акт

Амралт цалин давхардуулан 0.1 сая төгрөгийг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйл, ЭМС нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр зүйлийн 1.3 “ажил олгогч нь бүх ажилтныг жил бүр ээлжийн амралтаа заавал биеэр эдлүүлэх бололцоогоор хангаж эдлүүлнэ”-ыг, Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2 “ажилтанд ээлжийн амралтын хугацаанд нь ээлжийн амралтын олговор олгоно” гэсэн заалтыг зөрчсөн нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Тээвэр шатахууны зардлаас 0.1сая төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Албан шаардлага

Санхүүгийн тайлан болон татварын тодорхойлолт 0.3 сая төгрөгийн илүү, 2.2 сая төгрөгийн дутуу зөрүүтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан

авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тендерт шалгараагүй иргэн ААНБ-аас 1.9 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна” гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзса
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Говийн их дархан цаазат газрын “А” хэсгийн хамгаалалтын захиргаа	1	1	0	0	1	0	0	0
	НИЙТ	1	1	0	0	1	0	0	0

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Говийн их дархан цаазат газрын “А” хэсгийн хамгаалалтын захиргаа	5	14.6	1	9.9	2	0.3	2	4.4	0	0
	НИЙТ	5	14.6	1	9.9	2	0.3	2	4.4	0	0